



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/33/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123
Аудитор: Б.Мөнхбамбар
Утас: 70512127

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	6
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	6
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	7
4. АУДИТЫН ТАЙЛАН	8
4.1 Ерөнхий зүйл	8
4.2 Материаллаг байдал	8
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	8
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	9
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
4.5.1 Завсрын аудитын талаар	9
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	9

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН АМГАЛАНТ
ДЭНЖ УТУГ-ИЙН ДАРГА Ж.СҮРЭНХҮҮ
ТАНАА

2023.02.24 № 77

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТУГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТУГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТУГ-ын 27.1 сая төгрөгийн өөрийн орлого олж, 104.9 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарч, орон нутгаас 80.4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан нь цаашид өөрөө өөрийгөө санхүүжүүлэх боломжгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТУГ-ын 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилт, 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 90.4 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		01-р сарын 01	12-р сарын 31
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	83,050.1	24,141.0
1.1.2	Дансны авлага	1,667,684.4	910,684.4
1.1.6	Бараа материал	12,610,369.0	12,610,369.0
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	14,361,103.5	13,545,194.4
1.2.1	Үндсэн хөрөнгө	185,939,967.6	187,791,300.6
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	90,000,000.0	90,000,000.0
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	275,939,967.6	277,791,300.6
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	290,301,071.1	291,336,495.1
2.1.1.1	Дансны өглөг	-	58,883.0
2.1.1.3	Татварын өр	868,286.6	270,305.4
2.1.1.4	НДШ - ийн өглөг	3,372,209.9	662,650.3
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	270,008,845.4	271,860,178.4
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	274,249,341.8	272,852,017.0
2.2	Өр төлбөрийн нийт дүн	274,249,341.8	272,852,017.0
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	290,301,071.1	291,336,495.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	01-р сарын 01	12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		27,153,000.0
3	Нийт ашиг (алдагдал)	0	27,153,000.0
8	Бусад орлого		91,417,550.0
81	Бусад орлого (Татвар ногдохгүй орлого)		91,417,550.0
9	Борлуулалт, маркетингийн зардал		60,038,563.5
10	Ерөнхий ба удирдлагын зардал		54,282,049.4
12	Бусад зардал		1,546,883.0
30	Бусад зардал (татвар ногдох орлогоос хасагдах зардал)		1,546,883.0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	0	2,703,054.2
19	Орлогын татварын зардал		270,305.4
20	Татварын дараах ашиг (алдагдал)	0	2,432,748.8
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	2,432,748.8
24	Орлогын нийт дүн	0	2,432,748.8
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	01-р сарын 01	12-р сарын 31
---------------	----------	---------------	---------------

1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	107,611,883.00
111	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		27,153,000.00
115	Татаас, санхүүжилтийн орлого		80,400,000.00
116	Бусад мөнгөн орлого		58,883.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	108,427,792.07
121	Ажиллагчдад төлсөн		39,759,636.30
122	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		13,698,611.62
123	Бараа материал худалдан авахад төлсөн		30,601,249.00
124	Ашиглалтын зардалд төлсөн		17,105,961.52
125	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		1,145,486.00
127	Татварын байгууллагад төлсөн		3,601,647.63
129	Бусад мөнгөн зарлага		2,515,200.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(815,909.07)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	757,000.00
215	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		757,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	757,000.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	(58,909.07)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		83,050.11
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	83,050.11	24,141.04

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	0	0	0	0	0	0	16,051,729.3	16,051,729.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-	-
3	Залруулсан үлдэгдэл	0	0	0	0	0	0	16,051,729.3	16,051,729.3
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							2,432,748.8	2,432,748.8
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт		0	0	0	0	0		-
7	Зарласан ногдол ашиг								-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
9	2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	0	0	0	0	0	0	18,484,478.0	18,484,478.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ “Иргэдэд амралт, сувиллын чиглэлээр үйлчилгээ үзүүлэх” эрхэм зорилгын хүрээнд үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,035.4 мянган төгрөгөөр буюу 0.35 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	83.0	24.1	-58.9
Авлага	1,667.7	910.7	-757.0
Бараа материал	12,610.4	12,610.4	0.0
Үндсэн хөрөнгө	275,940.0	277,791.3	1,851.3
Нийт хөрөнгө	290,301.1	291,336.5	1,035.4
Өр төлбөр	4,240.5	991.8	-3,248.7
Урьдчилж орсон орлого	270,008.8	271,860.2	1,851.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	16,051.7	18,484.5	2,432.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	290,301.1	291,336.5	1,035.4

- Авлагын данс 757.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагын үлдэгдэл барагдсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө данс 277,791.3 мянган төгрөг болж 1,851.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үлдэх өртөггүй болсон хөрөнгийг дахин үнэлсэн нь нөлөөлсөн байна.
- Засгийн газрын хувь оролцоо данс 2,432.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 65,225.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,304.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад байр ашиглалттай холбоотой тогтмол

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

зардлууд 8,059.1 мянган төгрөгөөр өссөн, бичиг хэрэг, тээвэр шатахууны зардал 2,437.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Дээрх зардал өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Байр ашиглалттай холбоотой зардал: Өмнөх онд коронавирустэй холбоотой үйл ажиллагаа тогтмол явагдаагүй нь нөлөөлөл үзүүлсэн байна.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, орлого зарлагын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Амгалант дэнж УТҮГ-д завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	100
Зөвлөмж	3	-	3	-	100
Нийт дүн	4	-	4	-	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Амгалант дэнж УТҮГ нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 дугаар тогтоолоор татан буугдаж Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-т нэгтгэж байгаа тул үндсэн болон эргэлтийн хөрөнгийг зохиох журмын дагуу акт баримтаас хүлээлцүүлж, данс бүртгэл тусгасан эсэхийг тодруулан үзэх нь зүйтэй.